САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ТоС
МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ХОЛБОО



ЦЭНХЭР БОНД ГАРГАХ УДИРДАМЖ

Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр гаргах цэнхэр бондыг ангилах, хөрөнгийг хуваарилах, тайлагнах зах зээлийн нэгдсэн жишиг баримт бичиг

2026 он

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЦЭНХЭР БОНД ГАРГАХ УДИРДАМЖ

Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр гаргах цэнхэр бондыг ангилах, хөрөнгийг хуваарилах, тайлагнах зах зээлийн нэгдсэн жишиг баримт бичиг

/2026 оны 8 дугаар сар/

Энэхүү удирдамжийг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Цэнхэр санхүүжилтийн удирдамж (Хувилбар 2.0), Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны (ICMA) Ногоон бондын зарчим, Зээлийн зах зээлийн холбооны (LMA) Ногоон зээлийн зарчим, Монголын Ногоон таксономи болон Олон Улсын Санхүүгийн Корпорацтай хамтран боловсруулсан Голомт банкны Цэнхэр санхүүжилтийн хүрээ баримт бичгүүдэд тулгуурлан боловсруулав.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудаас усны нөөцийн хомсдол, усны чанар, гүний усны хэрэглээ, бохир усны менежмент зэрэг асуудалд нэн тэргүүнд анхаарч, шийдвэрлэх шаардлагатай болоод байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал юм. Үүний тулд дотоодын төдийгүй олон улсын хөрөнгө оруулалтыг татах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн боломжийг үр дүнтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд бид Олон Улсын Санхүүгийн Корпораци, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Голомт банктай хамтран манай улсын нөхцөлд нийцсэн "Цэнхэр бонд гаргах удирдамж"-ийг боловсруулаа. Энэхүү удирдамж нь аж ахуйн нэгж, байгууллагуудад цэнхэр санхүүжилт, тэр дундаа цэнхэр бонд гаргахад баримтлах суурь чиглэл болж, зах зээлд нэгдсэн ойлголт, ил тод байдал, зохистой зарчмыг төлөвшүүлэхэд чухал суурь болно гэдэгт итгэлтэй байна.

Түүнчлэн бид энэхүү удирдамжийг Монгол Улсад тогтвортой санхүүжилтийн шинэ санхүүгийн боломжийг бүрдүүлж, усны нөөцийг хамгаалах зорилгыг бодит хөрөнгө оруулалттай холбох чухал алхам гэж үзэж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, байгаль орчин, нийгэмд эерэг нөлөөтэй санхүүгийн хэрэгслийн зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид ч энэ чиглэлээр санхүүгийн зах зээлийн оролцогчид, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах болно.

Энэхүү удирдамжийг боловсруулах ажлыг түүчээлэн ажилласан Голомт банк болон хамтран боловсруулсан Олон Улсын Санхүүгийн Корпораци, Монголын тогтвортой санхүүжилтийн холбооны хамт олонд гүнээ талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Т.ЖАМБААЖАМЦ
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

ГОЛОМТ БАНКНЫ ӨМНӨХ ҮГ



Ус бол улс орны эдийн засгийн хөгжил, нийгмийн сайн сайхан, байгаль орчны тогтвортой байдлыг хангах стратегийн чухал нөөц баялаг юм. Монгол Улсын хувьд усны нөөцийн тархалт жигд бус, усны хэрэглээний дийлэнх хувь нь газрын доорх уснаас хамааралтай байдаг. Үүнтэй зэрэгцэн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны хомсдол, бохирдол, усны экосистемийн доройтол зэрэг сорилтуудтай нүүр тулсаар байна. Иймд усны нөөцөө хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх цэнхэр санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Цэнхэр санхүүжилтийн хөгжлийг дэмжих чухал хэрэгслүүдийн нэг нь цэнхэр бонд юм. Цэнхэр бондоор дамжуулан усны тогтвортой менежмент, бохир ус цэвэрлэгээ, усны үр ашигтай хэрэглээ, усны экосистемийн хамгаалал, нөхөн сэргээлт, тогтвортой аялал жуулчлал зэрэг салбаруудад хөрөнгө оруулалтыг татах замаар байгаль орчинд эерэг үр нөлөөг бий болгож чадна. Түүнчлэн эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой.

Голомт банкны санаачилгаар Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо хамтран Олон Улсын Санхүүгийн Корпорацийн техникийн туслалцаатай Монгол Улсын анхны “Цэнхэр бонд гаргах удирдамж”-ийг боловсруулан гаргалаа. Энэхүү удирдамжаар Монгол Улсад цэнхэр санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, зах зээлийн оролцогч талуудад олон улсын сайн туршлага, зарчимд нийцсэн арга зүйн нэгдсэн чиглэл өгөх, ил тод байдал, үр нөлөөг нэмэгдүүлэхийг зорилоо.

Санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгжүүд болон бусад оролцогч талуудад цэнхэр эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болохуйц аливаа төсөл, санал санаачилга, үйл ажиллагааг тодорхойлох, санхүүжүүлэх, үнэлэх, тайлагнахад энэхүү “Цэнхэр бонд гаргах удирдамж” бодит дэмжлэг болно гэдэгт итгэлтэй байна.

Бид цаашид ч усны тогтвортой менежмент, усны нөөцийн хамгаалал, экосистемийн нөхөн сэргээлтэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, Монгол Улсын цэнхэр санхүүжилтийн зах зээлийг олон улсын сайн туршлагатай нийцүүлэн хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, тууштай дэмжин ажиллах болно.

Хүндэтгэсэн,

А.ОДОНБААТАР
ГОЛОМТ БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХОЛБООНЫ ӨМНӨХ ҮГ



Монгол Улсад тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааны онцлог нь зохицуулалтын шаардлагаар бус зах зээлийн өөрийн санаачилгаар эхэлсэн явдал юм. 2013 онд Монголын арилжааны банкнууд Тогтвортой санхүүгийн санаачилгыг хамтран эхлүүлж, Тогтвортой санхүүгийн зарчмуудыг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрөн, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг зээлийн шийдвэр гаргалтад нэвтрүүлснээр энэхүү тогтолцооны суурь тавигдсан.

Түүнээс хойш бид тогтвортой санхүүгийн бүрэн дэд бүтцийг бүтээж ирлээ. 2018 онд Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураглал батлагдаж, 2019 онд Ногоон таксономийн хороо байгуулагдан, 2020 онд Ногоон таксономи батлагдаж, 2023 онд Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи болон өргөжсөн. Санхүүгийн зохицуулах хорооноос ногоон бондын зохицуулалтын орчныг бүрдүүлснээр ногоон болон нийгмийн бонд Монголын хөрөнгийн зах зээлд бие даасан хөрөнгийн ангилал болон хөгжсөн. Эдгээр алхам бүр дээр банкнууд тэргүүлж, зохицуулагч байгууллагууд дэмжиж, олон улсын түншүүд хөрөнгө оруулж ирсэн. Цэнхэр санхүүжилт ч мөн адил замаар эхэлж байна.

Ус бол Монгол Улсын хөгжлийн хамгийн эмзэг нөөц. "Алсын хараа-2050" бодлогын Зорилт 6.3-т тусгасан усны нөөцийн хомсдолоос сэргийлэх зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг зөвхөн улсын төсвөөр шийдвэрлэх боломжгүй. Иймд усны салбарт хувийн хэвшлийн хөрөнгийг татах санхүүгийн хэрэгсэл, түүнчлэн уг хэрэгслийг тодорхойлох нэгдсэн стандарт зайлшгүй шаардлагатай болж байна.

Голомт банк Монгол Улсад Цэнхэр санхүүжилтийн анхны хамрах хүрээ баримт бичгийг боловсруулж, олон улсын хараат бус үнэлгээгээр баталгаажуулсан нь энэ чиглэлийн эхлэлийг тавьсан чухал алхам боллоо. Банкны удирдлага, хамт олонд талархал илэрхийлье.

Мөн Олон Улсын Санхүүгийн Корпорацийн зүгээс Монгол Улсын тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд олон жилийн турш үзүүлж ирсэн тууштай дэмжлэгт гүнээ талархаж байна. ТоС Холбооны зүгээс энэхүү анхны туршлагыг зах зээлийн бүх оролцогчдод нээлттэй, нэгдсэн удирдамж болон ангилал зүйн шалгуур болгон хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад бэлэн байна.

Хүндэтгэсэн,

Э.АНАНД
МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЛАРХАЛ

Энэхүү Удирдамжийг Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Голомт банк, Дэлхийн банкны бүлгийн гишүүн байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС Холбоо) хамтран боловсруулла.

Удирдамжийг ОУСК-ийн "Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх II үе шат" болон ОУСК, Голомт банкны "Цэнхэр санхүүжилт ба Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо" төслүүдийн хүрээнд боловсруулав. "Ногоон санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх II үе шат" төслийг Япон улсын Засгийн газар санхүүжүүлсэн бөгөөд Монгол Улсад уур амьсгалын болон тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд үзүүлж буй өгөөмөр дэмжлэг, тууштай оролцоонд гүн талархал илэрхийлье.

Энэхүү Удирдамжийг Нэгдсэн үндэстний байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын бага хурлын 17 дугаар чуулган (UNCCD COP17)-ы үеэр зохион байгуулагдсан "Өндөр түвшний Тогтвортой санхүүжилтийн форум 2026"-ын хүрээнд олон нийтэд албан ёсоор танилцуулсан болно.

Мөн Удирдамжийг боловсруулахад мэдлэг, туршлагаа хуваалцаж, санал зөвлөмж өгсөн холбогдох байгууллагууд болон оролцогч талуудад талархал илэрхийлье. Тэдний оруулсан хувь нэмэр Удирдамжийн ач холбогдлыг нэмэгдүүлээд зогсохгүй зах зээлийн хэрэгцээ шаардлага болон олон улсын сайн туршлагатай нийцүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

ГАРЧИГ

1	ЗОРИЛГО БА ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	2
2	ХАМРАХ ХҮРЭЭ	3
3	НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	4
4	МОНГОЛ УЛСАД ЦЭНХЭР САНХҮҮЖИЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ	5
5	ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД БА ЗАХ ЗЭЭЛИЙН СТАНДАРТТАЙ НИЙЦСЭН БАЙДАЛ	6
6	ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ — ШААРДЛАГА ХАНГАСАН ЦЭНХЭР ТӨСЛИЙН АНГИЛАЛ	7
7	САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ	13
8	ТӨСӨЛ ҮНЭЛЭХ, СОНГОХ ҮЙЛ ЯВЦ	14
9	ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА	16
10	ТАЙЛАГНАЛ	17
11	ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ	19
12	СЗХ-НД БҮРТГҮҮЛЭХ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ	20
13	ХЯНАЛТ, МОНИТОРИНГ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ	21
14	УДИРДАМЖИЙГ ХЯНАХ, ШИНЭЧЛЭХ	22
15	ҮҮРЭГ ХҮЛЭЭХГҮЙ БАЙХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ	23



1 ЗОРИЛГО БА ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1.1

Цэнхэр бонд гаргах энэхүү удирдамж (цаашид “Удирдамж” гэх)-ийг Монголын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, бонд гаргагчийн цэнхэр бондыг ангилах, гаргах, хөрөнгийг зарцуулах, удирдах, тайлагнах нэгдсэн жишиг аргачлалыг тогтоох зорилгоор Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” буюу “Хороо” гэх)-ноос гаргав.

1.2

Энэхүү удирдамжийг СЗХ-ны үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх, Монгол Улсад тогтвортой, хариуцлагатай санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, дэмжих чиг үүргийн хүрээнд Монголын Ногоон таксономи, Монголын Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи болон Тогтвортой санхүүжилтийн замын зургийн зорилтуудтай нийцүүлэн боловсруулла.

1.3

Энэхүү удирдамж нь СЗХ-ны “Компанийн өрийн хэрэгслийг бүртгэх журам” (цаашид “Өрийн хэрэгслийн журам” гэх)-тай уялдан ашиглагдана. Бонд гаргагч өрийн хэрэгслийг “цэнхэр бонд” гэж нэрлэн бүртгүүлж гаргах бол Өрийн хэрэгслийн журамд заасан бүх шаардлагуудыг хангахаас гадна энэхүү удирдамжид тусгасан холбогдох шалгуурыг хангана. Удирдамжид тусгайлан зохицуулаагүй асуудалд Өрийн хэрэгслийн журмыг баримтална. Хоёр баримт бичгийг хамтад нь хэрэглэхдээ нэршил, хөрөнгийн зарцуулалт, цэнхэр бондын тайлагналтай холбоотой илүү нарийвчилсан шаардлагыг мөрдөнө.

1.4

Удирдамж нь Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны (ICMA) Ногоон бондын зарчим, Зээлийн зах зээлийн холбооны (LMA) Ногоон зээлийн зарчим, ОУСК-ийн Цэнхэр санхүүжилтийн удирдамж (Хувилбар 2.0) зэрэг олон улсын сайн туршлага болон ОУСК-тай хамтран боловсруулсан Монголын банкны салбарын анхны баримт бичиг болох Голомт банкны Цэнхэр санхүүжилтийн хүрээ (2026 оны 7 дугаар сар)-нд тулгуурласан.

1.5

Энэхүү удирдамж нь дангаараа хууль эрх зүйн болон хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш бөгөөд үнэт цаасны холбогдох хууль, мэдээлэл ил болгох журам, СЗХ-ны бүртгэлийн шаардлагыг орлохгүй. Удирдамж болон заавал дагаж мөрдөх хууль, журам, түүний дотор Өрийн хэрэгслийн журам хооронд ямар нэг зөрүү гарвал хууль, журмыг дагаж мөрдөнө.



2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1

Энэхүү Удирдамж нь Санхүүгийн зохицуулах хорооны батлсан “Өрийн хэрэгслийн журам”-ын дагуу бонд, өрийн бичиг болон түүнтэй адилтгах өрийн хэрэгслийг бүртгүүлж, нийтэд санал болгон гаргаж буй Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн захиргаа болон хуульд заасан бусад эрх бүхий этгээдэд (цаашид “Бонд гаргагч” гэх) хамаарна.

Бонд гаргагч нь өрийн хэрэгслийг усны нөөцийн хамгаалал, цэнгэг усны экосистемийн тогтвортой байдал, усны үр ашиг, бохирдлыг бууруулах болон усны тогтвортой менежментэд чиглэсэн үр дүнтэй уялдуулан “цэнхэр”, “цэнхэр бонд” эсхүл түүнтэй адилтгах нэршлээр ангилан гаргах тохиолдолд энэхүү Удирдамжийн шаардлагыг дагаж мөрдөнө.

2.2

Энэхүү Удирдамжийг цэнхэр бондын зэрэгцээ цэнхэр зээл болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт нь тодорхой бусад цэнхэр санхүүжилтийн хэрэгсэлд сайн дурын үндсэн дээр хэрэглэж болно.

Мөн тогтвортой байдалтай уялдсан санхүүгийн хэрэгсэлд ашиглагдах гүйцэтгэлийн гол үзүүлэлт нь энэхүү Удирдамжийн 10.2-т заасан шаардлага хангасан цэнхэр төслийн ангилалтай холбоотой үр дүн, нөлөөллийн нэг буюу хэд хэдэн үзүүлэлтэд суурилсан тохиолдолд тухайн санхүүжилт, хөрөнгө (холбогдох бол), зорилтот үзүүлэлт, гүйцэтгэлийн үнэлгээ, хөрөнгийн удирдлага болон тайлагналын үйл ажиллагааг энэхүү Удирдамжид тусгасан зарчим, шаардлагатай нийцүүлэн зохион байгуулж болно.

Энэхүү Удирдамжийг хэрэглэх нь цэнхэр санхүүжилтийн хэрэгслийн ил тод байдал, харьцуулалт, найдвартай байдлыг сайжруулж, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудад ус болон цэнгэг усны тогтвортой байдлын үр дүнг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэхэд чиглэнэ.

2.3

Зах зээлд олон нийтэд санал болгох, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах хэлбэрээр байршуулж буй өрийн хэрэгсэлд “цэнхэр бонд” гэсэн нэршил ашиглахын тулд бонд гаргагч нь энэхүү Удирдамжийн 6-9 дүгээр бүлэгт заасан дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шаардлагыг бүрэн хангасан бөгөөд тэдгээртэй нийцэж буйгаа зохих баримт, мэдээллээр нотлон харуулсан байна.

Мөн бонд гаргагч нь энэхүү Удирдамжийн 12 дугаар бүлэгт заасан бүртгэл, баталгаажуулалт, мэдээллийн ил тод байдал болон бусад холбогдох үе шатыг бүрэн хэрэгжүүлсэн байна



3 НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Цэнхэр бонд:	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг энэхүү удирдамжийн дагуу зөвхөн шаардлага хангасан цэнхэр төсөлд зарцуулах өрийн хэрэгсэл.
Шаардлага хангасан цэнхэр төсөл:	Удирдамжийн 6 дугаар хэсгийн аль нэг ангиллын шалгуурыг хангаж, 7 дугаар хэсгийн санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад ороогүй төсөл эсвэл хөрөнгө.
Бонд гаргагч:	Энэхүү удирдамжийн дагуу цэнхэр бонд эсвэл түүнтэй адилтгах цэнхэр санхүүжилтийн хэрэгсэл гаргаж буй Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд.
Хөндлөнгийн хоёрдогч үнэлгээ (SPO):	"Бонд гаргагчийн цэнхэр бондын хүрээг хүлээн зөвшөөрөгдсөн зах зээлийн холбогдох стандарттай нийцэж буй эсэхэд бонд гаргахаас өмнө хараат бус байгууллагын хийсэн үнэлгээ.
БОНЭУТ:	Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо — байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах, хянахад чиглэсэн бонд гаргагчийн дотоод тогтолцоо.
Ажлын хэсэг:	Шаардлага хангасан цэнхэр төслийг шалгах, сонгох, хянах зорилгоор бонд гаргагчийн байгуулсан баг, ажлын хэсэг.



4 МОНГОЛ УЛСАД ЦЭНХЭР САНХҮҮЖИЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ

4.1

Усны аюулгүй байдал нь Монгол Улсын хөгжил, өрсөлдөх чадварын стратегийн тэргүүлэх чиглэл юм. Цэнгэг усны нөөц хязгаарлагдмал, жигд бус тархалттай далайд гарцгүй орны хувьд Монгол Улсад хотжилт, үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлт, газрын доорх усны хамаарал, бохир усны менежментийн дутагдал, гол, нуур, намгархаг газар болон орчны экосистемийн бохирдлоос үүдэх дарамт үлэмж их нэмэгдэж байна.

4.2

Цэнхэр санхүүжилт нь усны нөөцийг тогтвортой удирдах, хамгаалах, сэргээх, үр ашигтай ашиглахад чиглэсэн төсөл, үйл ажиллагаанд хувийн хэвшлийн болон институтийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татан төвлөрүүлэх чухал механизм мөн.

Монгол Улс нь далайд гарцгүй орон тул энэхүү Удирдамжид хэрэглэж буй “цэнхэр санхүүжилт” гэсэн ойлголт нь далай, тэнгисийн экосистемээс ялгаатайгаар зөвхөн цэнгэг усны нөөц, усны аюулгүй байдал, усны экосистемийн тогтвортой байдалтай холбоотой үйл ажиллагааг хамарна.

Олон улсын хэмжээнд далайн эрэг, далай тэнгисийн экосистемд төвлөрсөн цэнхэр санхүүжилтийн удирдамж, ангиллын тогтолцоо ашиглагддаг боловч энэхүү Удирдамжийн хүрээнд төсөл, үйл ажиллагааны шаардлага хангасан эсэхийг үнэлэхдээ далайн эрэгт ойр байрлах байдал, далайн бүсэд хэрэгжиж буй эсэх зэрэг шалгуурыг хэрэглэхгүй. Харин тухайн төсөл нь Монгол Улсын усны аюулгүй байдал, цэнгэг усны нөөцийн хамгаалал, усны тогтвортой менежмент болон усны экосистемийн нөхөн сэргээлтэд бодитой хувь нэмэр оруулж байгаа эсэхийг үндсэн шалгуур болгон үнэлнэ.

4.3

Энэхүү удирдамжийн дагуу санхүүжилтийн шаардлага хангасан цэнхэр төсөл бүр Тогтвортой хөгжлийн зорилго 6 (ТХЗ 6: Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах)-тай холбоотой дараах 6 зорилтуудад хувь нэмэр оруулах шаардлагатай: (6.1) аюулгүй ундны ус, (6.2) ариун цэвэр, эрүүл ахуй, (6.3) бохир ус цэвэрлэгээ ба бохирдлыг бууруулах, (6.4) ус ашиглалтын үр ашиг, (6.5) усны нөөцийн нэгдсэн менежмент, (6.6) устай холбоотой экосистемийг хамгаалах.

---

[1] Монгол Улсын хувьд энэхүү Удирдамжийн хүрээнд хамаарах шаардлага хангасан цэнхэр төслүүд нь үндсэндээ Тогтвортой хөгжлийн зорилго 6 (ТХЗ 6)-д голлон хувь нэмэр оруулах чиглэлтэй байна. ТХЗ 14 болон олон улсын “тогтвортой цэнхэр эдийн засаг”-ийн холбогдох удирдамжид (жишээлбэл, Тогтвортой цэнхэр эдийн засгийг санхүүжүүлэх бондын талаарх Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны удирдамж) заасан заалтуудыг зөвхөн цэнгэг усны биологийн олон янз байдал, усны экосистем, эсхүл хил дамнасан усны нөлөөлөлтэй холбоотой тохиолдолд хамаарна гэж ойлгоно.



5 ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД БА ЗАХ ЗЭЭЛИЙН СТАНДАРТТАЙ НИЙЦСЭН БАЙДАЛ

5.1

Энэхүү удирдамжийн дагуу гаргах цэнхэр бонд нь Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны Ногоон бондын зарчим, Олон улсын зээлийн зах зээлийн холбооны Ногоон зээлийн зарчимтай нийцсэн дараах дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг хамарна:

1	ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	6-Р ХЭСЭГ
2	ТӨСӨЛ ҮНЭЛЭХ, СОНГОХ ҮЙЛ ЯВЦ	8-Р ХЭСЭГ
3	ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА	9-Р ХЭСЭГ
4	ТАЙЛАГНАЛ	10-Р ХЭСЭГ

5.2

Бонд гаргагч нарийвчилсан арга зүйд ОУСК-ийн Цэнхэр санхүүжилтийн удирдамж (Хувилбар 2.0) болон Удирдамжийн холбогдох зохицуулалт, ялангуяа 6 дугаар хэсгийн цэнгэг усны төслийн ангилал, 7 дугаар хэсгийн санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтыг мөрдөнө.

5.3

СЗХ нь цэнхэр санхүүжилтийн зах зээлийн хөгжил, үндэсний тэргүүлэх чиглэлийн өөрчлөлт, өмнөх хугацаанд бонд гаргасан туршлагад үндэслэн энэхүү удирдамжийг шинэчилж болно. Суурь өөрчлөлтийг СЗХ-ны цахим хуудсанд нийтэлж, бүртгэлтэй бонд гаргагч болон зах зээлийн оролцогчдод мэдээлнэ.



6 ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ — ШААРДЛАГА ХАНГАХ ЦЭНХЭР ТӨСЛИЙН АНГИЛАЛ

6.1

Цэнхэр бонд бүрийн хувьд татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй тэнцэх дүнг зөвхөн доорх дөрвөн ангиллын нэг буюу түүнээс дээш ангилалд хамаарах шинэ эсвэл хэрэгжиж буй шаардлага хангасан цэнхэр төсөлд зарцуулна. Ангиллыг ОУСК-ийн Цэнхэр санхүүжилтийн удирдамж (Хувилбар 2.0), Голомт банкны Цэнхэр санхүүжилтийн хүрээ баримт бичигт суурилан Монгол орны далайд гарцгүй байдал, цэнгэг устай нөхцөлд тохируулан боловсруулаа.

A. Ангилал 1: Ус ба бохир усны тогтвортой менежмент

ТХЗ 6-д оруулах үндсэн хувь нэмэр: ТХЗ[2] 6.1, 6.2, 6.3, 6.4

Тогтвортой хөгжлийн зорилт 6.1	Аюулгүй ундны ус	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.2	Ариун цэвэр, эрүүл ахуй	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.3	Бохир ус цэвэрлэгээ ба бохирдлыг бууруулах	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.4	Ус ашиглалтын үр ашиг	

[2] Тогтвортой хөгжлийн зорилт

Тогтвортой усан хангамж ба усны үр ашиг

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Цэнгэг усны нөөцийн хүртээмжийн үнэлгээнд үндэслэн, усны олборлолт болон хэрэглээг тухайн усны эх үүсвэрийн байгалийн нөхөн сэргэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хэрэгжүүлж, усны нөөцийн хэт ашиглалт, хомсдолоос урьдчилан сэргийлэх усны менежментийн үйл ажиллагаа.

> Бүтээгдэхүүний нэгж эсвэл үйлчилгээ хүртэгч өрхөд ногдох усны хэрэглээний үр ашгийг хамгийн багадаа 10 хувиар сайжруулсан шинэ, өргөтгөсөн, сэргээн засварласан эсвэл шинэчлэгдсэн ус хангамжийн дэд бүтэц (ус татах, цэвэрлэх, дамжуулах) бүхий төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Суурь түвшинтэй харьцуулахад усны түгээлтийн систем дэх бодит усны алдагдлыг хамгийн багадаа 10 хувиар бууруулах үр дүнтэй ус дамжуулах, түгээх дэд бүтцийг шинээр байгуулах, өргөтгөх, солих, шинэчлэх эсвэл сэргээн засварлах төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Суурь үзүүлэлттэй харьцуулахад усны хэрэглээг хамгийн багадаа 10 хувиар бууруулах үр дүн бүхий ус хэмнэх технологи, тоног төхөөрөмж, процессын сайжруулалт болон усны үр ашигтай хэрэглээг дэмжих менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

Бохир ус цэвэрлэх ба дахин ашиглах

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Хот суурин газар, үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ болон орон сууцны хэрэглэгчдэд үйлчлэх бохир ус цуглуулах, дамжуулах, цэвэрлэх дэд бүтэц, үүнд төвлөрсөн бохир усны шугам сүлжээнд нийлүүлэхээс өмнөх урьдчилсан цэвэрлэгээний байгууламж болон газар дээр нь бүрэн цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх эсвэл сэргээн засварлах төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Цэнгэг усны эх үүсвэрээс ус олборлох хэрэгцээг бууруулах эсвэл усны биетэд үзүүлэх бохирдлын ачааллыг бууруулах зорилгоор цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах, эргэлтэд оруулах эсвэл дахин ашиглалтын дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Газрын доорх ус болон ойролцоох цэнгэг усны экосистемийн бохирдлыг бууруулах зорилгоор төвлөрсөн бус ариун цэврийн систем, септик байгууламж, өтгөн лагийг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах, дахин ашиглах болон аюулгүй зайлуулах менежментийн тогтолцоог шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх эсвэл сэргээн засварлах төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй усны дэд бүтэц

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Үерийн эрсдэлийг бууруулж, хурдас[3], хуванцар, химийн бодис болон бусад бохирдуулагчийг гол, нуур, намгархаг газар, газрын доорх усны нөхөн сэргэх бүсэд орохоос сэргийлэх ус зайлуулах, борооны ус, үерийн менежментийн систем.

Б. Ангилал 2: Усанд ээлтэй тойрог эдийн засаг ба тогтвортой үйлдвэрлэл

ТХЗ 6-д оруулах үндсэн хувь нэмэр: ТХЗ 6.3, 6.4, 6.5

Тогтвортой хөгжлийн зорилт 6.3	Бохир ус цэвэрлэгээ ба бохирдлыг бууруулах	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.4	Ус ашиглалтын үр ашиг	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.5	Усны нөөцийн нэгдсэн менежмент	

Хурдас[3] гэдэг нь салхи, ус, мөсөн гол болон бусад гадаад хүчний нөлөөгөөр чулуулаг өгөршиж эвдэрсний үр дүнд үүсэж, газрын гадаргуу дээр хуримтлагдсан элс, шавар, хайрга, лаг зэрэг жижиг болон том хэсгүүдийн цуглуулга юм.

Усанд ээлтэй бүтээгдэхүүн

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Цэнгэг усны экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хортой бодисыг орлуулах, халах эсвэл цэнгэг усанд нийлүүлэх азот, фосфор, хуванцар, химийн бодис болон бусад бохирдуулагчийн ачааллыг бууруулах тогтвортой түүхий эд, материал ашиглан үйлдвэрлэсэн ахуйн, хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн болон хэрэглээний бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Гол, нуур, намгархаг газар болон газрын доорх усны чанарыг хамгаалах зорилгоор бохирдуулагчийн ачааллыг нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн гарц тутамд хамгийн багадаа 20 хувиар бууруулах, эсвэл фосфат, азотын суурьтай нийлэг бордоог байгальд ээлтэй, биологийн задралтай хувилбараар орлуулах төсөл, бүтээгдэхүүн болон үйл ажиллагаа.

> Өртгийн сүлжээнд ашиглагдаж буй чулуужсан түлшний гаралтай нийлэг мяндсыг нүүрстөрөгчийн ялгарал багатай, биологийн задралд ордог тогтвортой төрлийн мяндсаар (жишээлбэл, Lyocell) орлуулах үйл ажиллагаа.

Хуванцар дахин боловсруулах

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Хог хаягдлын хэмжээг бууруулж, материалын эргэлтийг дэмжих зорилгоор дахин боловсруулах, биологийн задралд орох боломжтой ургамлын гаралтай хуванцар, сав баглаа боодлын үйлдвэрлэл, хэрэглээ.

> Цэнгэг усны экосистемд үзүүлэх хуванцар хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дахин боловсруулсан эсвэл дахин ашигласан хуванцар материалыг үйлдвэрлэлийн орц, түүхий эдэд ашиглах төсөл, бүтээгдэхүүн болон үйл ажиллагаа.

> Цэнгэг усны эх үүсвэрийг хуванцар бохирдлоос хамгаалах зорилгоор хуванцар хаягдал цуглуулах, дахин боловсруулах байгууламжийн төсөл эсвэл хуванцар сав баглаа боодлыг байгальд ээлтэй, тогтвортой болон нөхөн сэргээгдэх материалаар орлуулах төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

B. Ангилал 3: Цэнгэг усны эхийг хамгаалах ба нөхөн сэргээх

ТХЗ 6-д оруулах үндсэн хувь нэмэр: ТХЗ 6.5, 6.6

Тогтвортой хөгжлийн зорилт 6.5	Усны нөөцийн нэгдсэн менежмент	
Тогтвортой хөгжлийн зорилт 6.6	Устай холбоотой экосистемийг хамгаалах	

Амьдрах орчны хамгаалал ба нөхөн сэргээлт

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

Гол, нуур, намгархаг газар, газрын доорх усны тогтолцоо зэрэг цэнгэг усны экосистемийн экологийн бүрэн бүтэн байдал, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, сайжруулах эсвэл сэргээх зорилгоор нэгдсэн экосистемийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

Усны чанар, нөөцийн төлөв байдлыг бодит цаг хугацаанд хянах, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах замаар усны экосистемийн хамгаалал, сэргээн засварлалт болон уур амьсгалын тэсвэртэй байдлыг дэмжих дижитал мэдээллийн систем, мониторингийн технологи, тоног төхөөрөмж.

Усны нөөцийг хамгаалах, хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлэх, мөн экосистемийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор намгархаг газар сэргээх, гол мөрний эргийг бэхжүүлэх, мод бут болон ургамал нөхөн сэргээж тарих зэрэг байгальд суурилсан шийдлүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

Г. Ангилал 4: Тогтвортой аялал жуулчлал

ТХЗ 6-д оруулах үндсэн хувь нэмэр: ТХЗ 6.6

Тогтвортой хөгжлийн зорилт 6.6	Устай холбоотой экосистемийг хамгаалах.	

Тогтвортой аялал жуулчлал

Хамрах ТХЗ



Үндсэн зориулалт

> Цэнгэг усны экосистем, биологийн олон янз байдлын хамгаалал, усны тогтвортой менежментийг дэмжих зорилгоор боловсрол, олон нийтийн мэдлэг олголт, сургалт, байгаль тайлбарлах зочны төв болон тогтвортой байдлын гэрчилгээжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа.

> Цэнгэг усны экосистемийн ойролцоо байрлах, байгаль орчны нөлөөллийг бууруулж, орон нутгийн иргэдэд үр өгөөжтэй байх зарчмаар хэрэгждэг, олон улсын тогтвортой аялал жуулчлалын GSTC, Preferred by Nature эсвэл адил хүлээн зөвшөөрөгдөх стандартаар баталгаажсан аялал жуулчлалын үйл ажиллагаа (амралтын газар, зочид буудал, завины үйлчилгээ, эко аялал зэрэг).



7 САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

7.1

Бонд гаргагч нь Монгол Улсын санхүүгийн салбарт түгээмэл хэрэглэгддэг санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт болон ОУСК-ийн Цэнхэр санхүүжилтийн удирдамжид (Хувилбар 2.0) заасан дараах үйл ажиллагаанд цэнхэр бондын хөрөнгийг зарцуулахгүй:

1. *Монгол Улсын хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, гэрээгээр хориглосон үйл ажиллагаа.*
2. *Зохицуулалтгүй сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодисыг тариалах, үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, худалдаалах үйл ажиллагаа.*
3. *Хууль бус мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа.*
4. *Садар самуун, бэлгийн мөлжлөг, хүний наймааг сурталчлах, зохион байгуулах, дэмжих үйл ажиллагаа.*
5. *Албадан хөдөлмөр, мөлжлөгийн хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг ашиглах, ажилтны эвлэлдэн нэгдэх болон хамтын хэлэлцээ хийх эрхийг хязгаарлахтай холбоотой үйл ажиллагаа.*
6. *Галт зэвсэглэл үйлдвэрлэх, худалдаалах үйл ажиллагаа.*
7. *Пирамид тогтолцоо, олон түвшний маркетингийн үйл ажиллагаа.*
8. *Холбогдох хууль тогтоомж болон зөвшөөрлийн шаардлага хангаагүй экспорт, импорт, хил дамнасан худалдааны үйл ажиллагаа.*
9. *Олон улсын эсвэл үндэсний тусгай хамгаалалттай газарт явуулах, эсвэл түүнийг доройтуулах үйл ажиллагаа.*
10. *Биологийн олон янз байдал, соёл, түүхийн өвийг хамгаалах олон улсын конвенцоор хориглосон үйл ажиллагаа.*
11. *Асбест агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ.*
12. *Полихлорт бифенил (PCB) агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах, ашиглах үйл ажиллагаа.*
13. *Озоны үе давхаргыг задалдаг бөгөөд олон улсын гэрээгээр хориглосон бодисын үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ.*
14. *Олон улсын хэмжээнд хориглосон эм, пестицид, химийн бодис болон аюултай материалын үйлдвэрлэл, худалдаа.*
15. *Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлсийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES)-ын хавсралтад бүртгэлтэй зүйл, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний хууль бус эсвэл зохисгүй худалдаа.*
16. *Тэсэлгээ, хордуулах бодис болон бусад сүйтгэх аргаар загас агнах, зохицуулалтгүй болон хууль бус загас агнуурын үйл ажиллагаа.*
17. *Олон улсын гэрээ, хэлэлцээрээр хориглосон аюултай болон хортой хог хаягдлын тээвэрлэлт, боловсруулалт, устгал.*
18. *Хуулиар хамгаалагдсан ой, өндөр хамгаалалтын үнэ цэнтэй ойн бүсэд мод бэлтгэх, эсвэл ийм үйл ажиллагааг дэмжих мод бэлтгэлийн тоног төхөөрөмжийн худалдаа.*
19. *Тогтвортой эх үүсвэрээс гарал үүсэл нь баталгаажаагүй мод, ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа.*
20. *Роттердам болон Стокгольмын конвенцоор хориглосон үйл ажиллагаа.*
21. *Спиртийн агууламж 28%-иас өндөр согтууруулах ундааны үйлдвэрлэлийн орлого нь тухайн байгууллагын болон түүний хамаарал бүхий этгээдийн нийт орлогын 20%-иас дээш хувийг бүрдүүлдэг үйл ажиллагаа*
22. *Чулуужсан түлшид суурилсан эрчим хүч үйлдвэрлэл болон түүнтэй холбоотой дэд бүтэц, технологийн шинэ бүтээн байгуулалт, өргөтгөл, хүчин чадлын нэмэгдлийг дэмжих үйл ажиллагаа.*

7.2

Бонд гаргагч нь төслийн урт хугацааны уур амьсгалын нөлөөллийг үнэлж, чулуужсан түлшний хамаарал үүсгэх, нүүрстөрөгчийн өндөр ялгаралтай хөрөнгө, дэд бүтцэд түгжигдэх (carbon lock-in) эрсдэлээс зайлсхийх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Техник, эдийн засгийн хувьд боломжтой тохиолдолд нүүрстөрөгчийн ялгарал багатай, эрчим хүчний өндөр үр ашигтай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар бүхий технологи, шийдлийг давуу эрхтэйгээр сонгон ашиглана.



8 ТӨСӨЛ ҮНЭЛЭХ, СОНГОХ ҮЙЛ ЯВЦ

8.1

Бонд гаргагч нь шаардлага хангасан цэнхэр төсөл, хөрөнгө оруулалтыг үнэлэх, сонгохдоо одоо мөрдөгдөж байгаа эсвэл тусгайлан байгуулсан тогтвортой санхүүгийн засаглалын бүтцийг ашиглана. Энэхүү засаглалын бүтэц нь төслийн нийцлийг үнэлэх, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянах, санхүүжилтийн шийдвэрийг баталгаажуулах чиг үүрэг бүхий байх бөгөөд дор хаяж дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

1

Цэнхэр бондын хүрээний хэрэгжилт, шаардлага хангасан цэнхэр төслүүдийг үнэлэх, сонгох, хянах болон бондын хөрөнгийн зориулалтын ашиглалтад хяналт тавих чиг үүрэг бүхий бонд гаргагчийн гүйцэтгэх удирдлагаар ахлуулсан эсвэл түүнд тайлагнадаг дээд түвшний засаглалын байгууллага (жишээлбэл, Тогтвортой хөгжлийн хороо)

2

Удирдамжийн 6, 7 дугаар хэсгийн шалгуур, санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтын дагуу шаардлага хангасан цэнхэр төслийг шалгах, баримтжуулах, баталгаажуулах, хянах, тайлагнах Ажлын хэсэг эсвэл хариуцсан нэгж.

3

Санал болгосон төсөл, үйл ажиллагааг шаардлага хангасан цэнхэр төслүүдийн бүртгэлд оруулахаас өмнө тухайн төсөл нь Тогтвортой хөгжлийн зорилго 6 (Цэвэр ус, ариун цэвэр)-д хувь нэмэр оруулах үр дүнтэй, энэхүү Удирдамжид заасан байгаль орчны холбогдох зорилтууд болон хэрэглэж буй зах зээлийн стандарт, шалгуурт нийцэж буй эсэхийг үнэлж, баримтжуулан баталгаажуулна.

4

Байгууллагын стратеги, үндэсний зохицуулалтын шаардлага, тогтвортой санхүүгийн зах зээлийн хөгжил, олон улсын холбогдох стандартын өөрчлөлтийг тусгах зорилгоор Цэнхэр бондын хүрээг тогтмол хянаж, шинэчилнэ.

Төсөл бүр шаардлага хангасан цэнхэр төслийн бүртгэлд орохын өмнө дараах гурван шалгуурыг давсан байна:

i. Тогтвортой хөгжлийн зорилго 6 (Цэвэр ус, ариун цэвэр)-д хувь нэмэр оруулах үр дүнтэй байх;

ii. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох зорилтыг оролцуулан байгаль орчин, нийгмийн бусад зорилтуудад ноцтой хор хохирол учруулахгүй байх;

iii. Шаардлага хангасан цэнхэр төсөл нь үнэт цаас гаргагчийн Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу үнэлэгдсэн байх бөгөөд үндэсний зохицуулалтын шаардлага болон хамаарах олон улсын байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарттай нийцсэн байх.

8.2

Бонд гаргагч нь цэнхэр бондын хөрөнгөөр санхүүжих бүх төсөл, үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн зохих хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд үнэт цаас гаргагчийн Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо (БОНЭУТ), холбогдох үндэсний хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчин, нийгмийн стандартуудыг мөрдөнө.

Бонд гаргагч нь ашиглаж буй байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын стандарт, аргачлалыг тодорхойлж мэдээлэх бөгөөд үүнд, тухайлбал, Олон улсын санхүүгийн корпорацын (IFC) Гүйцэтгэлийн стандартууд, Дэлхийн банкны бүлгийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (EHS) удирдамж болон түүнтэй дүйцэхүйц олон улсын стандартыг ашиглаж болно.

Холбогдох тохиолдолд дээрх шаардлагыг Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, хяналт-шинжилгээг эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх бөгөөд өндөр эрсдэлтэй төсөл, үйл ажиллагаанд илүү нарийвчилсан үнэлгээ, сайжруулсан хяналт, санхүүжилтийн дараах мониторингийг хэрэгжүүлнэ.

8.3

Энэхүү удирдамжийн хүрээнд зөвхөн Дэлхийн банкны бүлэг болон олон талт хөгжлийн банкуудын Парисын хэлэлцээртэй нийцлийн арга зүйн шаардлагыг хангасан төсөл санхүүжих эрхтэй. Санхүүжигдэх төсөл нь байгаль орчин, нийгмийн бусад зорилтуудад ихээхэн хор хохирол учруулахгүй байх (Do No Significant Harm) зарчмыг хангасан байна.

8.4

Шаардлага хангасан цэнхэр төслийг бонд гаргагчийн дээд түвшний хяналтын байгууллага эсхүл түүнээс эрх олгосон батлах байгууллага эцэслэн хянан хэлэлцэж батална. Батлагдсан төслийг энэхүү удирдамжийн 9 дүгээр хэсэгт заасан Шаардлага хангасан цэнхэр төслийн бүртгэлд бүртгэнэ.



9 ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

9.1

Бонд гаргагч нь цэнхэр бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, хуваарилалтыг дотоод бүртгэлийн тогтолцоогоор дамжуулан хянаж бүртгэнэ. Уг бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана:

i. Холбогдох санхүүгийн хэрэгсэл
ii. Төслийн ангилал
iii. Хуваарилсан санхүүжилтийн хэмжээ
iv. Шинэ санхүүжилт эсхүл дахин санхүүжилт эсэх төлөв
v. Хүлээгдэж буй үр нөлөөний үзүүлэлтүүд
vi. Шаардлага хангасан төслийн шалгуурт нийцэхээ больсон тохиолдолд түүнийг орлуулсан төслийн мэдээлэл.

9.2

Бонд гаргагч нь цэнхэр бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн дүн болон түүнтэй холбоотой байгаль орчин, нийгмийн үр нөлөөг тогтвортой санхүүгийн нэгээс олон хэрэгсэл, бүтээгдэхүүн, хөтөлбөрийн хүрээнд давхардуулан тооцохоос сэргийлэх систем, дотоод хяналтын механизмыг хэрэгжүүлнэ.

9.3

Цэнхэр бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийг дахин санхүүжилтэд ашиглах тохиолдолд, өөрөөр заагаагүй бол бонд гаргасан өдрөөс өмнөх 36 сарын хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, олгосон санхүүжилт болон хэрэгжүүлсэн шаардлага хангасан цэнхэр төслүүдийг хамруулж болно. Бондын хөрөнгийн дийлэнх хувийг шинэ санхүүжилтэд хуваарилна.

9.4

Бонд гаргагч нь цэнхэр бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг бонд гаргасан буюу хөрөнгийг хүлээн авсан өдрөөс хойш 24 сарын дотор шаардлага хангасан цэнхэр төслүүдэд бүрэн хуваарилахыг зорино. Хэрэв хөрөнгийг бүрэн хуваарилахад илүү урт хугацаа шаардагдах бол тухайн хугацааны үндэслэл, тайлбарыг санал болгох баримт бичигт тусгана.

9.5

Татан төвлөрүүлсэн боловч шаардлага хангасан цэнхэр төслүүдэд хараахан хуваарилаагүй хөрөнгийг бүрэн хуваарилах хүртэл бонд гаргагчийн мөнгөн хөрөнгө удирдах бодлого, журамд нийцүүлэн бэлэн мөнгө, бэлэн мөнгөтэй адилтгах хөрөнгө, мөнгөний зах зээлийн хэрэгсэл болон бусад хөрвөх чадвар өндөртэй санхүүгийн хэрэгсэлд түр байршуулж болно.

Хуваарилаагүй хөрөнгийг энэхүү удирдамжийн 7 дугаар хэсэгт заасан санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагаа, төсөл, хөрөнгөд шууд болон шууд бусаар зарцуулахыг хориглоно.

9.6

Цэнхэр бондын хүрээнд барьцаа хөрөнгө ашиглах тохиолдолд бонд гаргагч нь барьцаа хөрөнгийн зориулалт, ашиглалт, эдийн засгийн үйл ажиллагааг энэхүү удирдамжийн 6 дугаар хэсэгт заасан шаардлага хангасан цэнхэр төслийн ангилалтай нийцүүлэхийг зорино.



10 ТАЙЛАГНАЛ

10.1

Бонд гаргагч нь цэнхэр бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүрэн хуваарилах хүртэл хөрөнгийн хуваарилалт болон үр нөлөөний тайланг жилд хамгийн багадаа нэг удаа нийтэлнэ. Хөрөнгийг бүрэн хуваарилсны дараа шаардлага хангасан цэнхэр төслийн багц, хөрөнгийн хуваарилалт эсхүл тайлагнасан үр нөлөөнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд тайланг тухай бүр шинэчлэн нийтэлнэ.

Тайланг цэнхэр бондын бие даасан тайлан хэлбэрээр эсхүл бонд гаргагчийн жилийн тайлан, тогтвортой байдлын тайлан болон бусад олон нийтэд зориулсан тайлагналын баримт бичигт тусган нийтэлж болно. Уг тайлан нь Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгө оруулагчид болон бусад сонирхогч талуудад нээлттэй, хүртээмжтэй байна.

Хөрөнгийн хуваарилалтын тайлан

Хөрөнгийн хуваарилалтын тайланд дараах мэдээллийг тусгана:

1. *Шаардлага хангасан цэнхэр төслүүдэд хуваарилсан санхүүжилтийн нийт дүн, түүнчлэн төслийн ангилал тус бүрд хуваарилсан хөрөнгийн хэмжээ.*
2. *Шинэ санхүүжилт болон дахин санхүүжилтийн эзлэх хувь хэмжээ.*
3. *Нууцлал, мэдээллийн хамгаалалтын шаардлагыг харгалзан санхүүжүүлсэн эсхүл дахин санхүүжүүлсэн шаардлага хангасан цэнхэр төслүүдийн товч тайлбар эсхүл нэгтгэсэн мэдээлэл.*
4. *Хуваарилаагүй хөрөнгийн үлдэгдэл, түүнийг түр байршуулсан хөрөнгө оруулалтын төрөл болон холбогдох удирдлагын арга хэмжээ.*

10.2
Үр дүн, нөлөөллийн тайлан

Боломжтой тохиолдолд бонд гаргагч нь шаардлага хангасан цэнхэр төслүүдийн үр дүн болон үр нөлөөний үзүүлэлтүүдийг тайлагнах бөгөөд тайланд ашигласан арга зүй, гол таамаглал, суурь үзүүлэлт, тооцооллын аргачлал, мэдээллийн эх сурвалж болон холбогдох Тогтвортой хөгжлийн зорилт 6 (ТХЗ 6)-ын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдуулсан мэдээллийг тусгана.

Үр нөлөөний тайлагнал нь боломжтой хэмжээнд бодит үр дүнг илэрхийлэх тоон үзүүлэлтэд үндэслэх бөгөөд аргачлал, хамрах хүрээ, тооцооллын үндсэн зарчмыг ил тод мэдээлнэ.

Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Цэнхэр санхүүжилтийн удирдамж (Blue Finance Guidelines, Version 2.0)-тай нийцүүлэн шаардлага хангасан цэнхэр төслийн ангилал тус бүрээр тайлагнах боломжтой жишиг үр дүн болон үр нөлөөний үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Шаардлага хангасан ангилал	Жишиг үр дүн, нөлөөллийн үзүүлэлт
1. Ус ба бохир усны тогтвортой менежмент	Байгалийн эх үүсвэрээс цуглуулсан усны хэмжээ ($м^3$/жил) Усны хэрэглээний бууралт ($м^3$/жил) Хэмнэсэн усны хэмжээ ($м^3$/жил) Үйлчилгээ авсан/үр өгөөж хүртсэн хүний тоо (хүн/жил) Цэвэрлэсэн бохир усны хэмжээ ($м^3$/жил) Дахин ашигласан бохир усны хэмжээ/хувь ($м^3$/жил; %)
2. Усанд ээлтэй ба тойрог эдийн засгийн тогтолцоо	Нийт бүтээгдэхүүнд усанд ээлтэй бүтээгдэхүүний эзлэх хувь (%) Орлуулсан бордоо эсвэл хуванцрын жин/хэмжээ ба хувь (тонн/жил; %) Хуванцар дахин боловсруулах хүчин чадал (тонн/жил) Үйлчилгээ авсан/үр өгөөж хүртсэн хүний тоо (хүн/жил)
3. Амьдрах орчны хамгаалал ба нөхөн сэргээлт	Хамгаалсан, сайжруулсан болон/эсвэл сэргээсэн голын урт эсвэл усны экосистемийн талбай (км эсвэл м2/жил) Үйлчилгээ авсан/үр өгөөж хүртсэн хүний тоо (хүн/жил)
4. Тогтвортой аялал жуулчлал	Гэрчилгээтэй тогтвортой үйл ажиллагаа эрхлэгчийн тоо (GSTC, Green Globe, Preferred by Nature) Тогтвортой аялал жуулчлалын үйл ажиллагаанд шинээр бий болсон ажлын байрны тоо Үйлчилгээ авсан/үр өгөөж хүртсэн хүний тоо (хүн/жил)



11 ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

11.1
Бонд гаргахын өмнөх хөндлөнгийн хоёрдогч үнэлгээ

Бонд гаргагч нь цэнхэр бонд гаргахаас өмнө цэнхэр бондын хүрээ нь Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны (ICMA) Ногоон бондын зарчим, Олон улсын зээлийн зах зээлийн холбооны (LMA) Ногоон зээлийн зарчим болон энэхүү удирдамжийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлсэн хөндлөнгийн хоёрдогч үнэлгээ (Second-Party Opinion, SPO)-г мэргэшсэн, хараат бус этгээдээр гаргуулна.

Хөндлөнгийн хоёрдогч үнэлгээний тайланг бонд гаргагч нь өөрийн цахим хуудас болон бусад тохиромжтой мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд нээлттэй байршуулна.

Бондын танилцуулга, цэнхэр бондын хүрээ эсхүл шаардлага хангасан цэнхэр төслийн шалгуурт материаллаг өөрчлөлт оруулсан тохиолдолд бонд гаргагч нь уг өөрчлөлтийг анхны хөндлөнгийн хоёрдогч үнэлгээг гаргасан байгууллагаар эсхүл өөр мэргэшсэн хараат бус үнэлэгчээр хянуулж, шаардлагатай бол үнэлгээг шинэчлэн гаргуулна.

11.2
Шаардлага хангасан цэнхэр төслийн үнэлгээ

Тайлант хугацаанд шаардлага хангасан цэнхэр төслийн багцад шинээр бүртгэсэн төслийн хувьд тухайн төсөл нь энэхүү удирдамжид заасан шалгуур, санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцэж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор хараат бус гуравдагч талын үнэлгээ хийлгэхийг зөвлөж байна.

11.3
Хараат бус баталгаажуулалт

Бонд гаргагч нь цэнхэр бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүрэн хуваарилах хүртэл хөрөнгийн хуваарилалтын тайлан болон үр дүн, үр нөлөөний тайланд жилд хамгийн багадаа нэг удаа хараат бус хөндлөнгийн аудит эсхүл баталгаажуулалт хийлгэнэ.



12 СЗХ-НД БҮРТГҮҮЛЭХ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ

12.1

Монголын дотоодын зах зээлд цэнхэр нэршилтэй бонд гаргах этгээд СЗХ-ны Өрийн хэрэгслийн журмын дагуу уг хэрэгслийг бүртгүүлнэ. Бонд гаргагч нь холбогдох бүртгэлийн хүсэлттэй хамт эсвэл түүний хавсралтаар цэнхэр бондтой холбоотой дараах материалыг ирүүлнэ:

1. *Удирдамжийн 5 дугаар хэсгийн үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг хамарч, 6 дугаар хэсгийн шаардлага хангасан ангилал болон 7 дугаар хэсгийн санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалттай нийцэж буйг харуулсан бонд гаргагчийн цэнхэр бондын танилцуулга, хүрээ баримт бичиг.*
2. *Удирдамжийн 11.1-д заасан бонд гаргахын өмнөх хөндлөнгийн хоёрдогч үнэлгээ.*
3. *Удирдамжийн 8 дугаар хэсэгт заасан засаглал, үнэлгээний үйл явцын нотолгоо, үүнд хариуцсан хяналтын байгууллага болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг.*
4. *Удирдамжийн 9 дүгээр хэсэгт заасан хөрөнгийн удирдлага, хяналтын зохицуулалтын тайлбар.*
5. *Удирдамжийн 10, 11 дүгээр хэсгийн тасралтгүй тайлагнал, хөндлөнгийн үнэлгээний үүргийг биелүүлэх амлалт.*

12.2 СЗХ нь Өрийн хэрэгслийн журмын дагуу бүртгэлийн хүсэлтийг хянахтай хамт ирүүлсэн материал энэхүү удирдамжид нийцсэн, бүрэн эсэхийг шалгаж, уг журамд заасан хугацаанд өрийн хэрэгслийг "цэнхэр бонд" гэж нэрлэн бүртгэж болох эсэхийг баталгаажуулна. СЗХ-ны баталгаажуулалт нь энэхүү удирдамжтай нийцсэн нийцлийг илэрхийлэх бөгөөд хөрөнгө оруулалтын зөвлөгөө, зээлийн үнэлгээ, байгаль орчны үр дүнгийн баталгаа болохгүй.

12.3 СЗХ энэхүү удирдамжийн дагуу гаргасан цэнхэр бондын олон нийтэд нээлттэй бүртгэл хөтөлж болно. Бүртгэлд бонд гаргагч, өрийн хэрэгсэл, гаргасан огноо, хөндлөнгийн хоёрдогч үнэлгээ хийсэн байгууллага, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалт болон нөлөөллийн тайлангийн холбоосыг тусгана.



13 ХЯНАЛТ, МОНИТОРИНГ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

13.1

СЗХ нь бонд гаргагч энэхүү удирдамжийг үргэлжлүүлэн мөрдөж буйг нотлох шаардлага хангасан цэнхэр төслийн бүртгэл, хуваарилалт болон үр дүн, нөлөөллийн тайлан, холбогдох баталгаажуулалтын дүгнэлтийг хэдийд ч шаардаж болно.

13.2

Бонд гаргагч татан төвлөрүүлсэн хөрөнгийг буруу хуваарилах, тайлан гаргахгүй байх, санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад тусгасан үйл ажиллагааг санхүүжүүлэх зэргээр энэхүү удирдамжийг ноцтой зөрчсөн гэж СЗХ тогтоовол зах зээлийн шударга байдлыг хамгаалах, "ногоон угаалтаас" сэргийлэх зорилгоор залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардах, дараагийн удаа гаргах өрийн хэрэгсэлд "цэнхэр бонд" нэршил ашиглах эрхийг түдгэлзүүлэх болон/эсвэл үнэт цаасны холбогдох хуулийн дагуу зохицуулалтын болон хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах дараагийн шатны байгууллагад шилжүүлж болно.

13.3

Бонд гаргагч нь Өрийн хэрэгслийн журам, СЗХ-ны бусад дүрэм, мэдээлэл ил тод болгох үүрэг, үнэт цаасны хуулийн бүх шаардлагыг дагаж мөрдөнө. Энэхүү удирдамж нь тэдгээрийг орлохгүй.



14 УДИРДАМЖИЙГ ХЯНАХ, ШИНЭЧЛЭХ

14.1

Санхүүгийн зохицуулах хороо нь дотоодын болон олон улсын цэнхэр бонд, тогтвортой санхүүгийн зах зээлийн хөгжил, стандарт, шилдэг туршлагын өөрчлөлтийг тусгах зорилгоор зах зээлийн оролцогчид, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо болон холбогдох хөгжлийн түншүүдтэй зөвлөлдөн энэхүү удирдамжийн хэрэгжилт, нийцлийг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ. Ийнхүү хяналт, шинэчлэлийг гурван жил тутамд хамгийн багадаа нэг удаа хэрэгжүүлнэ.

14.2

Энэхүү удирдамжид оруулах суурь шинжтэй өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Мөн энэхүү удирдамжийн дагуу цэнхэр бонд гаргасан бонд гаргагчдад холбогдох шилжилтийн зохицуулалт, мөрдөх хугацаа болон хэрэгжилтийн шаардлагын талаарх мэдээллийг хүргүүлнэ.



15 ҮҮРЭГ ХҮЛЭЭХГҮЙ БАЙХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Энэхүү удирдамжийг цэнхэр бондын зах зээлийн хөгжлийг дэмжих, зохицуулалтын нэгдсэн ойлголт, сайн туршлагыг төлөвшүүлэх зорилгоор боловсруулав. Энэхүү удирдамж нь хөрөнгө оруулалтын зөвлөгөө, аливаа үнэт цаас, өрийн хэрэгслийг худалдан авах, эзэмших, худалдах талаар өгсөн зөвлөмж гэж үзэхгүй.

Энэхүү удирдамжийн дагуу үнэт цаас, өрийн хэрэгслийг "цэнхэр бонд" гэж ангилсан нь тухайн санхүүгийн хэрэгслийг хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, үнэлгээний байгууллага, хөндлөнгийн баталгаажуулагч, аудитын байгууллага болон бусад оролцогч талууд заавал хүлээн зөвшөөрөх баталгаа болохгүй. Түүнчлэн ийм ангилал нь байгаль орчин, нийгэм болон санхүүгийн тодорхой үр дүн, нөлөөлөл бий болно гэдгийг баталгаажуулахгүй.

Цэнхэр бондын хүрээнд санхүүжүүлсэн төсөл, үйл ажиллагааны шалгуурт нийцэл, үр дүн, үр нөлөөтэй холбоотой хариуцлагыг бонд гаргагч хүлээнэ. Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч тал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа өөрийн бие даасан үнэлгээ, шинжилгээг хийх бөгөөд холбогдох эрсдэлийг өөрсдөө үнэлнэ.

Бонд гаргалт бүрд бонд гаргагчийн зээлийн болон эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага, түүнчлэн тухайн хэлцлийн танилцуулга болон бусад эрх зүйн баримт бичигт заасан нөхцөлийг дагаж мөрдөнө.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ToC
MONGOLIAN SUSTAINABLE FINANCE ASSOCIATION